



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын хөрөнгөд бүртгэлтэй нийт 29,341,780.00 (хорин есөн сая гурван зуун дөчин нэгэн мянга долоон зуун наян) төгрөгийн балансын үнэ, 24,653,989.00 (хорин дөрвөн сая зургаан зуун тавин гурван мянга есөн зуун наян есөн) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төр, Засгийн үйлчилгээг эрхлэх газрын дарга Ж.Тамир, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний хэлтсийн дарга Ж.Бямбасүрэн, нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д оруулан бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

0002057



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2017 оны ~~04~~ дүгээр сарын ~~06~~-ны өдрийн ~~352~~
 дугаар тогтоолын хавсралт

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын балансаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын балансад
 шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)	
1	Тоосгон агуулах	1949	Ш	1	29,341,780.00	29,341,780.00	24,653,989.00	4,687,791.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН						29,341,780.00 (хорин есөн сая гурван зуун дөчин нэгэн мянга долоон зуун ная)	24,653,989.00 (хорин дөрвөн сая зургаан зуун тавин гурван мянга есөн зуун наян есөн)	4,687,791.00 (дөрвөн сая зургаан зуун наян долоон мянга долоон зуун ерэн нэгэн)